



91

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
**БИЕЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/27

Улаанбаатар хот


┌ Журам батлах тухай ─┐

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Биеийн тамир, спортын улсын хорооны дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




О.БАТТУЛГА

142419343

92
Биеийн тамир, спортын улсын хорооны
даргын 2024 оны 01 дугаар сарын 29-ны
өдрийн А/27 дугаар тушаалын хавсралт

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ
ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ЖУРАМ



Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь, байгууллагын хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Дотоод хяналт шалгалт нь хууль дээдлэх, хараат бус, ил тод, шударга, бодитой, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байх зарчимд тулгуурлана.

1.3. Дотоод хяналт шалгалтын зорилго нь байгууллагын үйл ажиллагаа, хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны болон өөрийн гаргасан шийдвэрт нийцэж байгаа эсэхэд байгууллагын хэмжээнд хяналт тавьж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхэд чиглэнэ.

**Хоёр. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах ажлын хэсэг,
түүний эрх үүрэг**

2.1. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахдаа энэхүү журам болон Монгол Улсын хууль, тогтоомж болон Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам" бусад дүрэм, журмыг баримтална.

2.2. Байгууллагын хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах ажлын хэсгийг тухай бүр батлах ба Биеийн тамир, спортын улсын хорооны даргын баталсан ажлын хэсэг /"цаашид комисс" гэх/ гүйцэтгэнэ.

2.3. Дотоод хяналт шалгалтын комисс, байгууллагын удирдлагад шууд захирагдах бөгөөд зохион байгуулалтын хувьд бусад бүтэц, нэгжээс хараат бус байна.

2.4. Дотоод хяналтыг төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн гэсэн хэлбэрээр зохион байгуулна.

2.5. Төлөвлөгөөт дотоод хяналт шалгалтыг байгууллагын жилийн гүйцэтгэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган батлуулж ажиллах бөгөөд төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасны дагуу хийж гүйцэтгэнэ.

2.6. Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь хяналт шалгалтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар жилд хоёроос доошгүй удаа, байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлнэ.

2.7. Дотоод хяналт шалгалтын комисс нь дараах нийтлэг эрх, үүрэгтэй байна:

2.7.1. Дотоод хяналт шалгалтын комисс, хорооны даргын баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, үр дүнг тайлагнах;

2.7.2. хяналт шалгалт явуулахдаа байгууллага, нэгжийн удирдлагатай шууд харилцаж, тэдгээрээс шаардлагатай мэдээ, судалгааг /мэдээллийг/ гаргуулан авах, холбогдох албан хаагчийн ажлыг шалгаж танилцах, илэрсэн зөрчил, дутагдлын талаар тайлбар гаргуулах;

2.7.3. илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах;

2.7.4. шаардлагатай бол илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг арилгах асуудлаар болон зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулах талаар байгууллагын даргад санал тавьж шийдвэрлүүлэх;

2.7.5. холбогдох дүрэм, журам, байгууллагын стандартыг боловсронгуй болгох талаар судалгаа авч, дүгнэлт гаргах;

2.7.6. дотоод хяналт шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, зөрчлийг нь арилгаж чадахгүй асуудлыг хууль хяналтын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хамтран ажиллах талаар санал боловсруулан удирдлагад танилцуулах;

2.7.7. байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилт болон зөрчлийн талаархи мэдээллээр удирдлагыг хангах;

2.7.8. хийсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх.

2.8. Энэхүү журмын 2.7.1-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дотоод хяналт шалгалтын комиссд аливаа дарамт, шахалт үзүүлэх, үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

Гурав. Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаа

3.1. Дотоод хяналт шалгалтыг дараах чиглэлээр зохион байгуулна:

3.1.1. Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актын хэрэгжилт болон байгууллагын хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтэд тавих хяналт шалгалт;

3.1.2. хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд тавих хяналт шалгалт;

3.1.3. өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт;

3.1.4. Тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын хэрэгжилтэд.

Дөрөв. Хариуцлага

4.1. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын дагуу буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомж, тухайн аж ахуйн нэгж, байгууллагын дотоод журамд заасан хариуцлагыг ногдуулна.

4.2. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал нь гэмт хэргийн шинжтэй бол асуудлыг хуулийн байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.